

## АЛБАН ХААГЧДЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭГ ХИЙСЭН ТУХАЙ ТОВЧ ТАЙЛАН

Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 38 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшин үнэлэх журам”-ыг дагаж мөрдөн ажиллаж байна.

2020 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэлийг нэгжийн дарга нар үнэлсэн ба тус газрын 5 газар, 3 хэлтсийн нийт 46 албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлж газрын даргын 2020 оны 06 дугаар сарын 22-ний өдрийн А-57 дугаар тушаалаар албан хаагчид үр дүнгийн урамшууллыг олгосон.

Мөн Газрын даргын 2020 оны 12 дугаар 20-ны өдрийн А-94 дүгээр тушаалаар албан хаагчдын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг үнэлэх чиг үүрэг бүхий үнэлгээний баг байгуулагдсан. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг Дарга нарын зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн 48 албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлсэн. Үүнээс “Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дэх хэсэгт Төрийн жинхэнэ албан хаагч төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх хугацаа дуусахад 3 сараас бага хугацаа үлдсэн үед тухайн албан тушаалд томилогдсон бол түүний тус хугацаанд гүйцэтгэсэн ажлыг дараагийн үнэлгээний хугацаанд нэгтгэн дүгнэж болно гэсний дагуу тус газарт ажилд томилогдоод 1-3 сарын хугацаанд ажиллаж байсан 4 албан хаагч болон газрын даргын тушаалаар сахилгын “сануулах шийтгэл” ногдуулсан 2 албан хаагчид үр дүнгийн урамшуулал олгохгүй байхаар тогтсон. Газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн А-97 дугаар тушаалаар албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгосон.

№	Нэгжийн нэр	Албан хаагчдын тоо, үнэлгээ /2020 оны эхний хагас/		Албан хаагчдын тоо, үнэлгээ /2020 оны жилийн эцэс/	
		Хангалттай 70-100 оноо	Хангалтгүй 70-аас доош	Хангалттай 70-100 оноо	Хангалтгүй 70-аас доош
1	Төрийн захиргааны удирдлагын газар	14	-	14	-
2	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн газар	4	-	5	-
3	Хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалтын газар	7	-	7	-
4	Судалгаа, шинжилгээний газар	4	-	6	-
5	Салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар	4	-	5	-
6	Хөрөнгө оруулалтын дэмжлэг, сурталчилгааны хэлтэс	4	-	5	-

7	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтэс	6	-	3	-
8	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитийн хэлтэс	3	-	3	-
9	Нийт	46		48	

Албан хаагчдын 2020 оны эхний хагас жилийн болон жилийн эцсийн ажлыг гүйцэтгэлийг үнэлэхдээ “Хангалттай”, “Хангалтгүй” гэсэн үнэлгээг өгсөн. Гүйцэтгэлийн зорилтын биелэлт / гүйцэтгэлийн хувь/ нь 70-аас доош хувьтай гарсан бол “Хангалтгүй”, 70-аас дээш хувьтай гарсан бол “Хангалттай” гэсэн үнэлгээгээр албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлсэн.

Нэгжүүдийн албан хаагчдын авсан үнэлэгдсэн байдлыг оноогоор гаргавал.

үнэлгээ	ТЗУГ	ХБТГ	ХОБЗГ	СХБЗГ	ХОДСХ	СШГ	ТХХТХ	ХШҮДАХ
<b>2020 оны эхний хагас жил</b>								
100-90%	13	4	7	4	4	2	6	3
89-70%	1	-	-	-	-	2	-	-
69-иас доош хувь	-	-	-	-	-	-	-	-
Нийт	14	4	7	4	4	4	6	3
<b>2020 оны жилийн эцэс</b>								
100-90%	14	3	6	4	-	4	6	4
89-70%	-	2	1	1	5	2		
69-иас доош хувь	-							
Нийт	14	5	7	5	5	6	6	4

Цаашид анхаарах зүйлс

Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 38 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшин үнэлэх журам”-ыг хэрэгжүүлэхэд арга зүйгээр хангах, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, гүйцэтгэлийг тайлагнахад илүү ойлгомжтой болгох.

